

**ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН СУМЫН ХӨРС, ЦАГ УУРЫН
НӨХЦӨЛД ДАСАН ЗОХИЦСОН ТАРИМЛЫН ТӨРӨЛ, СОРТЫГ
СОНГОН ШАЛГАРУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН**

Ж. Ганболд¹, Д.Мянганбаяр², Ж.Амарсайхан¹

1-ХААИС, Агробиологийн сургууль
2-ХААИС, Дорнод бүсийн эрдэм шинжилгээний салбар

e-mail: jganbold@rocketmail.com

ХУРААНГУЙ

2012 онд Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт 2 га-д судалгаа хийх зорилготой урини боловсруулан бэлтгэж, 2013 оноос 4 төрлийн таримал тарьж, сорт сорилтын туршилт, судалгаа хийж, тухайн Баянтүмэн сумын хөрс цаг уурын нөхцөлд дасан зохицсон чанар сайтай, арвин ургац өгдөг таримлын ургамлын төрлийг сонгох, сорт шалгаруулах ажлыг хийж гүйцэтгэв.

Таримлын төрлийг сонгох, сорт шалгаруулахсудалгааны ажлыг ХАА-н таримлын төрөл, сортыг судлах ерөнхий арга зүйгээр хийв.

Буудайн Дархан-74, Дархан-34, Дархан-144 сортууд 13.5-22.4 ц/га, арвайн Ноёт, Бурхант-1 сортууд 15.7-23.8 ц/га, хошуу будаа 35.6 ц/га, рапс 19.5 ц/га ургац тус тус авсан.

Судалгааны дүнгээр таримлын төрлүүд дотроос хошуу будаа хамгийн их буюу 35,6 ц/га ургац өгч шалгарч байна.

ТҮЛХҮҮР ҮГ: Сорт, буудай, арвай, хошуу будаа, рапс,

**СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО,
ЗОРИЛТУУД**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын хөрс цаг уурын нөхцөлд дасан зохицон ургах чадвартай таримал ургамлыг сонгон шалгаруулах гол зорилготой. Энэ зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. 2012 онд туршилт, судалгаа явуулах талбайг сонгож, уринш бэлтгэх.

2. Баянтүмэн сумын хөрс цаг уурын нөхцөлд дасан зохицон ургах чадвартай таримал ургамлыг сонгон шалгаруулах
3. Тариалж туршсан таримлын сортуудаас ямар сорт илүү ургацтайг тогтоох.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хөрс цаг уурын нөхцөл

Туршлага тавьсан газрын хөрс нь элсэнцэр хөнгөн хүрэн хөрстэй бөгөөд энэ талбайн хөрсний дээжийг 2012 онд ХААИС-ийн агрохимийн лаборатороор хийлгэсэн дүнг авав. Энэ шинжилгээний дүнгээр тус хөрс нь

хөдөлгөөнт калий дунд зэрэг, харин хөдөлгөөнт фосфор, азот хангалтгүй байгаа юм. Иймээс цаашид газарт тариалан эрхлэхэд тарьж байгаа таримлын онцлогийг харгалзан бордох шаардлагатайг харуулж байгаа юм /Хүснэгт 1/.

Хүснэгт 1

Туршлагын талбайн хөрсний агрохимийн шинжилгээний дүн

Хөрсний дээж авсан		РН	Ялзмаг	Шим тэжээлийн элементүүд 100мг/гр			
Хугацаа	Гүн /см/			P ₂ O ₅	K ₂ O	NH ₄	NO ₃
Тарихын өмнө	0-10	6.98	2.09	3.5	24	4.0	1.54
	10-20	7.03	2.00	2.8	12	3.4	0.6
	20-30	7.00	1.92	2.3	10	4.0	0.2
Хураалтын дараа	0-10	6.84	2.08	2.0	12	4.7	1.38
	10-20	6.77	1.62	1.6	16	4.4	0.3
	20-30	6.84	1.88	2.8	11	2.9	0.2

Хүснэгт 2

Цаг уурын үзүүлэлтүүд /Чойбалсан станцынхаар/

Үзүүлэлтүүд		5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	Нийлбэр
ОЖД	Тунадас/мм/	15.3	38.5	72.4	59	28	213.2
	Агаарын дундаж дулаан /градус/	11.6	18.2	20.8	18.4	11.1	80.1
2013он	Тунадас/мм/	31	60.1	101.2	174.8	21.2	388.3
	Агаарын дундаж дулаан /градус/	13.9	17.7	20.2	17.7	11.4	80.9

Туршлага тавьсан газарт цаг уурын харуул байхгүй учраас үүнээс 30км зайнд орших Чойбалсан станцын мэдээгээр цаг уурын үзүүлэлтүүдийг авсан болно.

Энэ нутагт ургалтын хугацаанд олон жилийн дунджаар 213,2 мм тунадас ордог бол 2013 онд 388,3 мм тунадас орсон нь 175.1 мм илүү тунадас унажээ. Энэ нь 2013 онд тариалсан бүх ургамлууд сайн ургах нөхцлийг буй болгосон. Мөн 5-9 саруудад олон жилийн дунджаас их

тунадас унасан, ургалтын хугацаанд тунадас жигд орсон нь харагдаж байна.

Энэ жил ургалтын хугацааны агаарын дундаж дулааны нийлбэр нь олон жилийн дунджийн орчим буюу 80,9 хэм буюу олон жилийн дунджийн орчим байв /Хүснэгт 2/. Энэ жилийн ургалтын хугацаанд орсон хур тунадас нь ихэнхдээ шөнө орж байсан учраас дулаан хангамжинд сөрөг нөлөө үзүүлээгүй юм. Энэ дулааны хувьд төрөл бүрийн таримал ургамалд тааламжтай жил болсон гэж үзэж болно.

Уринш боловсруулалт

Туршлага тавих талбайг 2012 оны 7-р сарын 20-21-нд МТЗ-80+ПН-3-35+ЗКК-6 агрегатаар 18-20 см гүн хагалж боловсруулав. Уриншийн дараахи

боловсруулалтыг Дорнод талын бүсэд баримтладаг ерөнхий технологийн дагуу хийж гүйцэтгэв.

Тарилт

Баянтүмэний хөрс цаг уурын нөхцөлд тохирсон таримал ургамлыг сонгон шалгаруулах зорилгоор 4 төрлийн таримлыг /буудай, арвай, хошуу буудай, рапс/ тарьж туршив.

Тарихын өмнө хог ургамал бага байсан учраас шууд СЗС-2,1 үрлэгчээр шууд тариалсан.

Тарилтыг 2013 оны 5-р сарын 27-ны өдөр МТЗ-80+СЗС-2,1 үрлэгчээр улаан буудайг 3,5 сая/ш, арвай, хошуу буудайг 3,0 сая/ш, рапсыг 5 сая/ш-ээр нэг га-д орохоор тооцож 6-8 см гүнд тариалсан. Харин рапсыг 4-5см гүнд тариалсан.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Соёолотыг 0,5 м²-д талбайгаас 3 цэгээс хэмжиж 1м²-д шилжүүлэн тооцов. Хээрийн соёололтыг 6-р сарын 7-8 –нд хэмжив. Энэ үед бүх таримлуудын соёололт жигдэрсэн байлаа. Буудайн сортуудын хээрийн соёололт 70.1-74.3

хувь, хошуу будаа 68 хувь, арвай 58.4-60.2 хувь рапс 73.6 хувьтай байна. Хээрийн соёололтыг сортуудаар авч үзвэл буудайн Дархан-144 сорт 74,3%, арвайн Бурхант-1 сорт 60.2%-ийн соёололттой хамгийн сайн байсан /Хүснэгт 3 /.

Хүснэгт 3

Д/д	Сортын нэр	Хээрийн соёололт					Соёололт %/
		1м ² -д дахь соёоны тоо					
		1	2	3	Нийлбэр	Дундаж	
1	Дархан-144	240	260	280	780	260,0	74,3
2	Дархан-74	230	270	260	760	253,3	72,4
3	Дархан-34	226	250	260	736	245.3	70.1
4	Хошуу будаа	206	180	226	612	204.0	68.0
5	Ноёд	160	166	200	526	175.3	58.4
6	Бурхант-1	190	140	212	542	180.7	60.2
7	Рапс	400	316	388	1104	368.0	73.6

Таримлын үзэгдэл зүйн ажиглалтыг соёололт, бутлалт, гол хатгалт, түрүүлэлт, залаалалт, сүүн болц, аарцан болцын үе шатуудаар хийв. Таримал, сортуудын ургалтын хугацааг соёололтоос аарцан болц хүртлэх хугацаагаар тооцож үзэхэд буудайн сортууд 88-96, хошуу будаа 91, арвай 82-84, рапс 96 хоногт тус тус болц гүйцэж байна.

Дорнод талын бүсийн нөхцөлд ургамал ургах хүйтэнгүй хоногийн тоо олон жилийн дунджаар 100-115 хоног байдаг бөгөөд судлагдсан 7 таримал, сортын ургалтын хугацаа 86-96 хоног байгаа нь энэ нутагт бүрэн боловсорч гүйцэх

боломжтойг батлаж байна. Үр тарианы таримлын механикжуулалтанд тохиромжтой өндөр нь 70 см-ээс багагүй, 100 см-ээс өндөргүй байх ёстой бөгөөд судалгаанд хамрагдсан бүх таримлуудын өндөр 74-99 см буюу тохиромжтой өндөртэй байна. /Хүснэгт 4/

Үр тарианы таримлын нэг ам метр дэх бүтээгдэхүүнт ишний тоо дунджаар 200-300 ширхэг байдаг бөгөөд бидний судалгаагаар ихэнх таримал ургамлын бүтээгдэхүүнт ишний тоо 210-279 ширхэг буюу тохиромжтой хэмжээнд байна.

Хүснэгт 4

д/д	Таримал, сортын нэр	Таримлын ургацын бүтэц, ургац		
		Ургамлын өндөр, см	Бүтээгдэхүүнт ишний тоо, ш	
		Ургац ц/га		
1	Буудай Дархан-74	98	228	13,5
2	Буудай Дархан-34	99	256	17,6
3	Буудай Дархан-144	97	225	22,4
4	Арвай Ноёт	59	210	15,7
5	Арвай Бурхант	74	148	23,8
6	Хошуу будаа	76	279	35,6
7	Рапс	87	139	19,5

Буудайн Дархан-74, Дархан-34, Дархан-144 сортууд 13.5-22.4 ц/га, арвайн Ноёт, Бурхант-1 сортууд 15.7-23.8 ц/га, хошуу будаа 35.6 ц/га, рапс 19.5 ц/га ургац тус тус авсан. Судалгааны

дүнгээр таримлын төрлүүд дотроос хошуу будаа хамгийн их буюу 35,6 ц/га ургац өгч шалгарч байна.

ДҮГНЭЛТ

1. Судалгааны дүнгээр таримлын төрлүүд дотроос хошуу будаа хамгийн их буюу 35,6 ц/га ургац өгч шалгарч байна.
2. Буудайн 3 сортоос Дархан-144 сортнь бусад 2 сортоосоо 8,9-4,8 ц/га-аар илүү ургац өгч шалгарлаа.
3. Арвайн 2 сорт соригдсоноос Бурхант сорт 23,8 ц/га ургац өгч Ноёт сортоосоо 8,1 ц/га-аар илүү ургац өгч шалгарсан байна.
4. Рапс 19,5 ц/га ургац өгсөнийг Баянтүмэний нөхцөлд боломжийн ургац гэж үзэж байгаа бөгөөд цаашид таримлын сэлгээнд тариалж болох тосны ургамлын нэг болох нь батлагдаж байна.

АШИГЛАСАНХЭВЛЭЛ

1. Ж. Ганболд. “Рапсыгүр, ногоон гэжээлд тарих ашигтай хугацааг тогтоох” туршлагын аргазүй. УГТЭШХ-ийн ЭЗ-ийн хурлын протокол №20/56 1982-06, 1982 он
2. Ж. Ганболд. Рапс тариалах технологи. ХААЯ-ны зурагт сонин №4, 1984 он
3. Ж. Ганболд. Дорнод талын бүсэд газар тариалан эрхлэх систем. Баруунурт хот, 1989 он,
4. Ж. Ганболд. Рапс. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл №2, 1985 он
5. Ж. Ганболд. Дорнод талын бүсэд үр тарианы таримлын селекци үрийн аж ахуйн чиглэлээр гүйцэтгэсэн судалгааны ажил, цаашдын зорилт. Чойбалсан хот, 2010 он

CONCLUSIONS

1. Preliminary results showing that in field experiments the oat was selected, which was give highest 3.56 t/ha yield out offourtypes of crops.
2. From studied 3 wheat varieties, theDarkhan-144 variety gave more than others 0.89-0.48 t/ha yield and considered as top variety, but it was matured late.
3. Barley 2 of varieties were tested,the Burkhan varietywas leading by giving2.38 t/ha yield, which was shown more than 0.81 t/ha yield of the Noyotvariety.
4. Rape with 1.95 t/ha yield considered appropriate yield in theBayantumencondition which was proved to be one of the oilseed plantsfor further crop rotation.